

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

Дэд бүлэг 1



## ХӨНДЛӨНГИЙН АУДИТИН ДҮГНЭЛТ

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Түмэн Шувуут ХК-ийн Хувьцаа эзэмшигчид танаа,

### Тусдаа санхүүгийн тайланийн аудитын тайлан

#### Дүгнэлт

Бид Түмэн Шувуут ХК (цаашид "Компани" гэх)-ийн 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тусдаа санхүүгийн байдлын тайлан, тусдаа дэлгэрэнгүй орлогын тайлан, тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан, тусдаа мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгуудаас бүрдсэн тусдаа санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний тусдаа санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон тусдаа санхүүгийн үр дүн болон тусдаа мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн, шударгаар илрхийлж байна гэж дүгнэж байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт -(цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хувьзэх үүргийг энэхүү тайланийн Тусдаа Санхүүгийн Тайланийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ын дүрэм" гэх)-ийн дагуу Компаниас хараат бус да НБЁЗОУСЗ-ын дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

#### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн үнэлэмжээр Аудитын гол асуудал нь тайлант жилийн тусдаа санхүүгийн тайланийн аудитад хамгийн ач холбогдолтой, нөлөө бүхий асуудал юм. Тусдаа санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудал бүрт тусад нь дүгнэлт гаргаагүй болно. Бид дараах асуудлыг гол асуудал гэж тодорхойлсон.

#### Аудитын гол асуудлууд

#### Бидний гүйцэтгэсэн аудитын горимууд

##### Биологийн хөрөнгийн үнэлгээ

СТОУС-ын дагуу биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хасч тооцсон бодит үнэ цэнээр нь хэмжиж, тайллагнахыг шаарддаг хэдий ч Компанийн биологийн хөрөнгийн хувьд бодит үнэ цэний нь тодорхойлох идэвхтэй зах зээл, харьцуулах мэдээлэл байхгүй тул Компанийн биологийн хөрөнгийг хуримтлагдсан хорогдол болон үнэ цэнийн бууруултыг хассан өртгөөр нь хэмжээн. Хорогдуулгын түвшинг тухайн биологийн хөрөнгөөс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хүлээн авах хугацааг үндэслэн тооцоолж, шулуун шугамын аргаар хорогдуулдаг.

2022 оны 12-р сарын 31-нээрх тусдаа санхүүгийн байдлын тайланд 3,651,258 мянган төгрөг (2022 оны 12-р сарын 31: 3,048,337 мянган төгрөг)-ийн биологийн хөрөнгө тусгагдсан. Санхүүгийн тайланийн Тодруулга 13-ыг үзнэ үү

Биологийн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- Биологийн хөрөнгийн үнэлгээг тодорхойлох дотоод процессын талаар ойлголт олж авч, холбогдох хяналтын үр ашигтай байдлыг үнэлсэн;
- 2022 оны 12-р сарын 31-нээрх биологийн хөрөнгийн хувьд түүврийн аргаар холбогдох өргтийг анхан шатны баримт руу шалгасан;
- Биологийн хөрөнгийн үнэлгээг тодорхойлоход ашигласан удирдлагын гол таамаглалын талаар удирдлагаас тайлбар авсан;
- Биологийн хөрөнгийн хорогдлын түвшинг тодорхойлсон удирдлагын тооцоолол болон үнэлэмжийн зохистой байдлыг үнэлсэн;
- Биологийн хөрөнгөтэй холбоотой санхүүгийн тайланийн тодруулгын бүрэн зөв, зохистой байдлыг үнэлсэн.

Onch & Company тухай

Onch & Company нь Монгол Улсын Оюуны өмчийн газарт бүртгэлтэй барааны тэмдэг юм. Энэхүү тэмдэгийг Онч Аудит ХХК, Онч Зөвлөх үйлчилгээ ХХК, Онч Татварын Зөвлөх үйлчилгээ ТМЗ ХХК-иуд ашиглах эрхтэй бөгөөд тэдгээр нь аудит, эрсдэлийн удирдлага, татвар болон хуулийн зөвлөгөө, консалтинг болон санхүүгийн зөвлөгөө зэрэг мэргэжлийн үйлчилгээг Монголын харилцагчад үзүүлдэг байгууллагууд юм.

Тус баримт бичигт ерөнхий мэдээлэл агуулагдсан бөгөөд энэхүү танилцуулгаар Onch & Company, түүний гишүүн компани, холбоотой талуудыг мэргэжлийн зөвлөгөө өгсөнд эсвэл үйлчилгээ үзүүлсэнд тооцохгүй. Та өөрийн санхүү, бизнест нөлөөлөхүйц ямарваа шийдвэр гаргах эсвэл үйлдэл хийхэс өмнө мэргэжлийн зөвлөхөд хандан зөвлөгөө авна уу. Энэхүү танилцуулгад найдаж шийдвэр гаргасан эсвэл үйлдэл хийсний улмаас ямарваа хохирол учирсан бол бид ямарваа хариуцлага хүлээхгүй болно.

© 2023. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Onch & Company-тай холбогдоно уу.

## Бусад мэдээлэл

Компанийн удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд захирлууд ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл агуулагдсан мэдээллийд орох бөгөөд тусдаа санхүүгийн тайлан болон энэхүү аудиторын дүгнэлт орохгүй. Энэхүү тусдаа санхүүгийн тайланд өгсөн манай аудиторын дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Тусдаа санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь тусдаа санхүүгийн тайлан эсвэл аудитын ажлын хүрээнд олж мэдсэн мэдээллээс материаллагаар зөрүүтэй эсвэл зөрүүтэй мэт харагдаж байгаа эсэхийг авч үзэх ёстой. Хэрэв бид хийсэн ажил дээрээ үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг алдаатай байна гэж үзвэл бодит мэдээллийг тайлагнах үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор ямар нэгэн тайлагнах зүйл байгаагүй болно.

## Тусдаа Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь тусдаа санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр тусдаа санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай залт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Удирдлага санхүүгийн тайланг бэлтгэх үедээ Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, уг чадамжид нөлөөлөхүйц нөхцөл байдлын талаар шаардлагатай үед тодруулах болон Компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

## Тусдаа Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Тусдаа санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай залт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг гарган гэрээт ажлын гэрээнд заасан эрх бүхий этгээд болох та бүхэнд хүргүүлэх нь бидний зорилго юм. Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бид аливаа бусад этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай залт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр тусдаа санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах тусдаа санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг баримталсан болно. Мөн түүнчлэн:

- Залилан болон алдаанаас үүсч болохуйц тусдаа санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлон үнэлж, уг эрсдэлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай болон зохистой аудитын баримт, нотолгоог олж авна. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийлийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлийг илрүүлэхгүй байх эрсдлээс өндөр байдаг. Учир нь залилан нь үгсэн тохирох, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, худал батламж гаргах болон дотоод хяналтыг зөрч өвлийн тусдаа санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.
- Бид Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус зөвхөн нөхцөл байдалд тохирох аудитын горимуудыг сонгох зорилгоор дотоод хяналтуудыг судалдаг.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлдэг.


**Тусдаа Санхүүгийн Тайланийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг (үргэлжлэл)**

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн тасралтгүй байх нөхцлийг үргэлжлүүлэн хангах Компанийн чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал байгаа гэж үзвэл тусдаа санхүүгийн тайланийн холбогдох тодруулгыг аудиторын дүгнэлтэнд тусгаж анхааруулах, мөн тэдгээр тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд бид дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай байдаг. Бид дүгнэлтээ аудиторын тайланийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотлох баримтан дээр үндэслэн гаргадаг. Тиймээс ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Компаний үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхэд саад учруулж болох юм.
- Тусдаа санхүүгийн тайланийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бүхэлд нь үнэлдэг ба ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдаар толилуулсан эсэхийг үнэлдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудын талаар мэдээлдэг ба үүнд аудитын үеэр аудиторын илрүүлсэн дотоод хяналтын томоохон алдаа болон дутагдал орно.

*Онч Аудит ХХК*

Онч Аудит ХХК  
Монгол улс, Улаанбаатар хот  
2023 оны 4-р сарын 24



Б. Анхтайван  
Партнер, МНБ



**ТҮМЭН ШУВУУТ ХК  
ТУСДАА САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
2022 ОНЫ 12 САРЫН 31  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

		Тодруулга	2022	2021
<b>ХӨРӨНГӨ</b>				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6	617,837	3,347,026	
Дансны ба бусад авлагага	7	3,874,088	1,704,692	
Урьдчилгаа төлбөр	8	1,254,575	2,636,337	
Бараа материал	9	5,742,300	7,646,299	
Эргэлтийн биологийн хөрөнгө	13.1	2,260,048	1,748,990	
		<b>13,748,848</b>	<b>17,083,344</b>	
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	11	30,262,115	22,972,024	
Биет бус хөрөнгө	12	363,842	394,090	
Эргэлтийн бус биологийн хөрөнгө	13.2	1,391,210	1,299,347	
Охин компани дахь хөрөнгө оруулалт, өртгөөр	10	814,565	814,565	
Бусад эргэлтийн бус хөрөнгө	24.1	5,767,454	4,830,567	
		<b>38,599,186</b>	<b>30,310,593</b>	
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>52,348,034</b>	<b>47,393,937</b>	
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>				
Богино хугацаат өр төлбөр				
Дансны ба бусад өглөг	14	3,403,176	1,841,931	
Гэрээний өр төлбөр	15	55,099	17,865	
Орлогын татварын өглөг	19.2	637,176	500,807	
Богино хугацаат зээл	16	5,051,989	5,205,541	
		<b>9,147,440</b>	<b>7,566,144</b>	
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээл	16	6,375,000	8,017,308	
<b>Нийт өр төлбөр</b>		<b>15,522,440</b>	<b>15,583,452</b>	
<b>Эзэмшигчдийн өмч</b>				
Хувьцаат капитал	17	4,000,000	4,000,000	
Нэмж төлөгдсөн капитал	18	8,007,687	8,007,687	
Хуримтлагдсан ашиг		24,817,907	19,802,798	
		<b>36,825,594</b>	<b>31,810,485</b>	
<b>Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		<b>52,348,034</b>	<b>47,393,937</b>	

Холбогдох тодруулгууд нь энэхүү тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ТҮМЭН ШУВУУТ ХК  
ТУСДАА ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2022 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	<b>Тодруулга</b>	<b>2022</b>	<b>2021</b>
Борлуулалтын орлого	20.1	45,955,858	35,912,919
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	20.2	<u>(42,829,480)</u>	<u>(32,918,823)</u>
<b>Нийт ашиг</b>		<b>3,126,378</b>	<b>2,994,096</b>
Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бодит үнэ цэнийн олз	23	10,604,411	8,134,243
Бусад орлого		-	95,962
Хүүгийн зардал	16.2	(652,097)	(3,051)
Ерөнхий ба удирдлагын зардал	21	(4,733,009)	(3,307,780)
Бусад олз ба (гарз)	22	<u>(107,923)</u>	<u>(25,976)</u>
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>8,237,760</b>	<b>7,887,494</b>
Орлогын албан татварын зардал	19	<u>(1,142,323)</u>	<u>(1,004,323)</u>
<b>Тайлан жилийн цэвэр ашиг</b>		<b>7,095,437</b>	<b>6,883,171</b>
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг</b>		<b>7,095,437</b>	<b>6,883,171</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр)</b>		<b>35.48</b>	<b>34.42</b>

Холбогдох тодруулгууд нь энэхүү тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ТҮМЭН ШУВУУТ ХК  
ТУСДАА ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2022 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	<b>Хувьцаат капитал</b>	<b>Нэмж төлөгдсөн капитал</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>Нийт</b>
<b>2020 оны 12 сарын 31-ний дүн</b>	<b>4,000,000</b>	<b>8,007,687</b>	<b>13,202,523</b>	<b>25,210,210</b>
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(282,896)	<b>(282,896)</b>
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	6,883,171	<b>6,883,171</b>
<b>2021 оны 12 сарын 31-ний дүн</b>	<b>4,000,000</b>	<b>8,007,687</b>	<b>19,802,798</b>	<b>31,810,485</b>
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	7,095,437	<b>7,095,437</b>
Зарласан ногдол ашиг (Тодруулга 17)	-	-	(2,080,328)	<b>(2,080,328)</b>
<b>2022 оны 12 сарын 31-ний дүн</b>	<b>4,000,000</b>	<b>8,007,687</b>	<b>24,817,907</b>	<b>36,825,594</b>

Холбогдох тодруулгууд нь энэхүү тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ТҮМЭН ШУВУУТ ХК  
ТУСДАА МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2022 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2022	2021
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>8,237,760</b>	<b>7,887,494</b>
Тохируулга:			
Элэгдлийн зардал	11,13	5,875,435	4,528,785
Хорогдолын зардал	12	30,248	31,668
Биологийн хөрөнгөтэй холбоотой үүссэн гарз			22,880
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн олз		(136,952)	(7,856)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (олз)/гарз	22	(15,838)	13,644
Бараа материал данснаас хассаны зардал	21	142,213	93,473
Хүүгийн зардал	16.2	652,097	606,040
Залруулгын нөлөөлөл			(42,896)
		<b>14,784,963</b>	<b>13,133,232</b>
Дансны ба бусад авлагын (өсөлт)/бууралт		(2,169,396)	1,705,685
Урьдчилгаа төлбөрийн бууралт/(өсөлт)		1,381,762	(969,676)
Бараа материалын бууралт/(өсөлт)		1,846,812	(4,220,724)
Дансны ба бусад өглөгийн өсөлт		1,199,592	390,262
Гэрээний өр төлбөрийн өсөлт		37,234	-
		<b>17,080,967</b>	<b>10,038,779</b>
Төлсөн орлогын татвар	19.2	(1,005,954)	(747,069)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>16,075,013</b>	<b>9,291,710</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн		(9,033,945)	(6,331,519)
Биологийн хөрөнгө худалдан авахад төлсөн	13	(4,599,605)	(3,553,922)
Эргэлтийн бус хөрөнгийн борлуулалтаас орж ирсэн		92,173	152,979
Охин компанийд олгосон санхүүжилт	24.2	(1,051,913)	(2,839,799)
Охин компанийд олгосон санхүүжилтээс төлөгдсөн	24.2	30,000	62,320
		<b>(14,563,290)</b>	<b>(12,509,941)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Авсан зээл	16.2	4,000,000	12,500,000
Төлсөн зээл	16.2	(5,776,282)	(4,681,930)
Төлсөн хүү	16.2	(882,907)	(591,653)
Неец өр төлбөрт хуримтлуулсан			(240,000)
Төлсөн ногдол ашиг	24.2	(1,654,364)	(1,600,000)
Хувьцаа эзэмшигчээс авсан санхүүжилт	24.2	412,000	-
Хувьцаа эзэмшигчээс авсан санхүүжилтээс төлсөн	24.2	(352,550)	-
		<b>(4,254,103)</b>	<b>5,386,417</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>			
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл		13,191	7,856
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн (бууралт)/өсөлт</b>		<b>(2,729,189)</b>	<b>2,176,042</b>
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>3,347,026</b>	<b>1,170,984</b>
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	6	<b>617,837</b>	<b>3,347,026</b>

Холбогдох тодруулгууд нь энэхүү тусдаа санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.